



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 14

Алтай

**Зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн
батлах тухай**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалт, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журмын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.


2. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зохион байгууллалтын арга хэмжээг авч ажиллахыг дарга /А.Дэлгэржаргал/-д даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 36-р тогтоол, 2014 оны 03-р сарын 31-ний өдрийн 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус хүчингүй болгосугай.



ДАРГА

А.ДЭЛГЭРЖАРГАЛ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2016 оны 03-р сарын 07-ны
өдрийн 44-р тогтоолын хавсралт

АЙМГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга: Аймгийн ИТХ-ын дарга

Нарийн бичгийн дарга: Цагдаагийн газрын дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг дарга
- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
- Хууль-зүйн хэлтсийн дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Сум дундын эрүүгийн хэргийн Ерөнхий шүүгч
- Аймгийн Ерөнхий прокурор
- Тагнуулын хэлтсийн дарга
- ШШГА-ны дарга
- Онцгой байдлын хэлтсийн дарга
- Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга
- Байгаль орчны газрын дарга
- Аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга
- Хүний эрхийн үндэсний комиссын Говь-алтай аймаг дахь ахлах мэргэжилтэн